



## ЭЛСНИЙ НҮҮЛТИЙГ СААРУУЛЯХ МЕХАНИК ХААЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

**Ажлын нэр:** Элсний механик хамгаалалтын ажил  
**Захиалагч байгууллага:** БОАЖЯ  
**Ажил үргэлжлэх нийт хугацаа:** 60-80 хоног  
**Ажиллах газар:** Говь-Алтай аймаг  
Хөхморьт сумын Сангийн далай нуур, Жаргалан сумын  
Эрээн нуур хамаарна.

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

УИХ-ын 2020 оны 23 тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.2.1, УИХ-ын 2020 оны 24 тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.5.4 зорилт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/39 тушаал болно.

### ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО

Томоохон элсэн тарамцаг тархсан сумын хэмжээнд элсний нүүлт хөдөлгөөнөөс улбаалсан доройтлоос дэд бүтцийн бүтээн байгуулалт, бэлчээрийг хамгаалах, ногоон байгууламжийн талбай, элсний нүүлтийн нэлэлэлд өртөж байгаа нуурууд, хот сууринг элсний нүүлт хөдөлгөөнөөс хамгаалах зорилгоор нүүлтийн хөдөлгөөнийг сааруулахад шинэлэг технологи нэвтрүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Улсын төсвийн хөрөнгөөр нийт 50,000,000 төгрөгөөр 6га талбайд элсний нүүлтийг тогтоон барих механик хамгаалалтыг хийнэ.

➤ Хөхморьт сумын Сангийн далай нууранд 3 га, Жаргалан сумын Эрээн нууранд 3га талбайд элсний нүүлт хөдөлгөөнийг сааруулах тогтоон барих зорилгоор сүрэл, зэгс, торон хамгаалалтыг хийнэ. Хөхморьт сумын Сангийн далай нуур, Жаргалан сумын Эрээн нуур тус бүрт 3 га буюу /өргөн 100м/\*урт 300м/ хэмжээтэй талбайг сүрэл /зэгс/ болон ногоон туузан тороор хольж 1x1, 1,5x1,5 метрийн хэмжээтэй шоо дөрвөлжин хэлбэртэй хийнэ.

➤ Торон механик хамгаалалтын хашлага нь газрын байршлын онцлогоос хамааруулан 1x1, 1,5x1,5 метрийн хэмжээтэй шоо дөрвөлжин байх бөгөөд өнцөг бүрт нь төмөр шон суурьлуулж сүлжиж хийнэ.

➤ Сүрэл, зэгсээр хийх хамгаалалт нь газрын гүнд 15-20 см суулгаж, газраас дээш 20-25 см өндөр буюу ил гарсан байхаар суулгана.

➤ Механик хамгаалалтыг байгальд ээлтэй материалыар хийнэ /туузан ногоон тор/

➤ Механик хамгаалалт хийхээр сонгосон талбайн онцлог шинж чанараас хамааруулан алсын хамгаалалт тузан хэлбэртэй /ногоон тор/ байх ба 1м орчим өндөртэй, уртын хэмжээ 1000м байна. Газрын гүнд 0,5м суулгаж, газрын гадаргаас дээш 1м байхаар 5м тутамд төмөр шон суурьлуулж торыг бөхөлж өгнө.

➤ Туузан /ногоон тор/ хамгаалалтыг механик хамгаалалт хийх талбайгаас хойш 200м зайд байрлуулж хийнэ.

➤ Механик (туузан, торлосон) хамгаалалт хийсэн газар ямарваа нэг ашиглалт хийхгүй байх анхааруулах тэмдэг, тэмдэглэгээнүүд байршуулсан байна.

### **ДӨРӨВ. БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ:**

- 4.1. ААН байгууллагын гэрчилгээ.
- 4.2. Ажлын график, төлөвлөгөө хээрийн ажлын маршрут
- 4.3. Төсвийн тооцоолол, үнийн санал
- 4.4. Өмнө тус ажилтай ижил төстэй хийсэн ажлын тайланг хавсаргах

### **ТАВ. ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА**


Хоёр тал гэрээ байгуулан гарын үсэг зурсан өдрөөс хойш 2 сарын хугацаанд элсний механик хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

### **ДОЛОО. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн ЗДТГ-ын хамтарсан ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Хамгаалалтын хаалт байгуулсан талбайг тухайн сумд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 4 хувь үйлдэх бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгальн нөөцийн бодлого зохицуулалтын газарт эх хувиар нь ирүүлнэ.

/Тайланд гүйцэтгэлийн явц, үр дүнг фото зургаар баталгаажуулсан байна./

### **БОЛОВСРУУЛСАН:**

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ЦӨЛЖИЛТ, СУРГАЛТ  
СУРТАЛЧИЛГАА, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН  Ч.АЛТАНГЭРЭЛ